

3.4 Эрүүл мэндийн статистик үзүүлэлт 2020 оны 11 сарын байдлаар:

- 2020 оны эхний 11 сарын байдлаар 197060 нийт үзлэг болж 71.7 хувь нь дүүргийн эрүүл мэндийн төвд, 28.2 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хийгдсэн байна. Үзлэгийн бүтцийн хувьд урьдчилан сэргийлэх үзлэг 38.42 хувь, өвчний учир амбулаторийн үзлэг 46.6 хувь, идэвхтэй хяналтын үзлэг 5.2 хувь, гэрийн идэвхтэй хяналтын үзлэг 9.4 хувь, гэрийн дуудлага 0.3 хувийг эзэлж байна.
- Стационарын тасагт 7326 өвчтөн хэвтэн эмчлүүлж нийт 49805 ор хоног ашигласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эмчлүүлсэн өвчтөн 133-ээр буурч, ор хоног 2484-р буурсан байна. Дундаж ор хоног 6.78 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.21-р буурсан, орны эргэлт 34.35 болж 0.62-өөр буурсан байна. Орны фонд ашиглалт 232.73 байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.61-аар буурсан байна.

№	Үзүүлэлтүүд	Нэгж	2019.11	2020.11	Зөрүү
1	Хэвтсэн өвчтөн	бодит тоо	7495	7350	-145
2	Гарсан өвчтөн	бодит тоо	7448	7326	-122
3	Эмчлүүлсэн өвчтөн	бодит тоо	7484	7351	-133
4	Ашигласан ор хоног	бодит тоо	52289	49805	-2484
5	Орны фонд ашиглалт	бодит тоо	244.34	232.73	-11.61
6	Орны фонд ашиглалтын хувь	бодит тоо	80.77	76.94	-3.84
7	Дундаж ор хоног	бодит тоо	6.99	6.78	-0.21
8	Орны эргэлт	бодит тоо	34.97	34.35	-0.62

- 2020 оны эхний 11 сарын байдлаар 569 эх төрсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 төрлөг буюу 0.2 хувиар өссөн байна. Нийт төрөлтийн 24.6 хувь нь кесаров хагалгаагаар төрсөн нь өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурсан байна. Амьгүй төрөлтийн 2 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан байна.
- Жирэмсний хяналтанд шинээр авсан эмэгтэйчүүдийн тоо 568, үүнээс эхний 3 сартайд хяналтанд орсон 457 (80.46 хувь) байна. Жирэмсний хяналтанд авсан эмэгтэйчүүдийн 10.2 хувь нь үр хөндүүлсэн байна.
- Нас баралтын нийт 130 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 тохиолдол буюу 8.4 хувиар өссөн байна. Эмнэлгийн нас баралтын 25 тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 19.2 хувийг эзэлж

байна. Үүнээс хоног болоогүй нас баралт 13 тохиолдол буюу эмнэлгийн нас баралтын 52.0 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өссөн байна. Нийт нас баралтын 39 тохиолдол буюу 30% нь хорт хавдрын, 18 тохиолдол буюу 13.8% нь гадны шалтгаант нас баралт байна.

- 2020 оны эхний 10 сарын байдлаар нялхсын эндэгдэл 4 тохиолдол өмнөх оны мөн /НЭМГ-ын эргэн мэдээлэхээс/ түвшинд, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

№	Үзүүлэлтүүд	нэгж	2019.11	2020.11	Зөрүү
1	Бүх нас баралт	бодит тоо	119	130	11
2	Эмнэлгийн нас баралт	бодит тоо	24	25	1
3	Хоног болоогүй нас баралт	бодит тоо	11	13	2
		хувь	45.8%	52.0%	6.2%
4	Нялхсын эндэгдэл	бодит тоо	4	4	0
		1000 амьд төрөлтөд	8.1	8.2	0.1
5	Перинаталь эндэгдэл	Бодит тоо	6	4	-2

Нас баралтын тэргүүлэх 3 шалтгаан:

№	Үзүүлэлт	Нэгж	2019.11	2020.11
1	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	Бодит	119/51	130/47
		Хувь	42.8	36.1
2	Хавдар	НБ/Бодит тоо	120/40	130/39
		Хувь	33.6	30
3	Осол гэмтэл, гадны шалтгаан	Бодит тоо	119/10	130/18
		Хувь	8.4	13.8

- Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувьд:
 - артерийн гипертензи өвчний эрт илрүүлэгт 18609 хүн хамрагдахаас 5604 хүн буюу 47.6%

- чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт 18609 хүн хамрагдахаас 5775 хүн буюу 48.8%
 - умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 1894 хүн хамрагдахаас 1287 хүн буюу 68%
 - хөхний хавдрын эрт илрүүлэгт 7565 хүн хамрагдахаас 4782 хүн буюу 63.2%
 - Элэгний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 763 хүн хамрагдахаас 622 хүн буюу 81.5 хувь нь тус тус хамрагдаад байна.
- Халдварт өвчний нийт 252 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 88 тохиолдол буюу 25.8 хувиар буурч 10000 хүн амд 86.92 болсон байна. Үүнд дотроо бэлгийн замын халдварт өвчин 167 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 4 тохиолдол буюу 10000 хүн амд 1.68 тохиолдлоор өссөн бол цочмог халдварт өвчний 71 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 85 тохиолдол буюу 10000 хүн амд 29.03-р буурсан байна. Мөн шинэ сүрьеэгийн 14 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7 тохиолдол буюу 33.3 хувиар буурсан байна.

№	Үзүүлэлтүүд	нэгж	2019.11	2020.11	Зөрүү
1	Бэлгийн замын халдварт өвчин	Бодит тоо	163	167	4
		10000 хүн амд	55.92	57.60	1.68
2	Цочмог халдварт өвчин	Бодит тоо	156	71	-85
		10000 хүн амд	53.52	24.49	-29.03
3	Сүрьеэ өвчин	Бодит тоо	21	14	-7
		10000 хүн амд	7.20	4.83	-2.38
4	Нийт халдварт өвчин	Бодит тоо	340	252	-88
		10000 хүн амд	116.64	86.92	-29.72

Статистик үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр: Байгууллагын хэмжээнд 51 төрлийн үндсэн үзүүлэлтийг сар, улирлаар дүгнэж ажилладаг бөгөөд энэ жилийн хувьд хоног болоогүй нас баралтыг бууруулах, перинаталь эндэгдэлийг бууруулах, 1-5 нас хүртэлх хүүхдийн эндэгдлийг бууруулах, гэрийн төрөлт болон хяналтгүй төрөлтийг бууруулах, үндсэн оношийн зөрүү бууруулах, мэс заслын хүндрэл гаргахгүй ажиллах, кесарво төрөлтийн хувийг бууруулах, ӨЭМТ-үүдийн гэрийн идэвхтэй эргэлтийн хувийг өсгөх, эрт илрүүлгийн үзлэгийн хувийг нэмэгдүүлэх зэрэг үзүүлэлтүүд дээр илүү анхаарч ажилласан. 2020 онд мэс заслын тоо, төрөл нэмэгдсэн, хүндрэл гараагүй, эмнэлгийн дотоод халдвар бүртгэгдээгүй, нялхсын эндэгдэл, перинаталь эндэгдэл, кесарво хагалгааны хувь буурсан. ӨЭМТ-

үүдийн гэрийн идэвхтэй эргэлтийн хувь өссөн, эрт илрүүлгийн үзлэгийн хувь өссөн амжилттай ажилласан.